



МОНГОЛ УЛС
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

15141 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Самбуугийн гудамж 11, Засгийн газрын 11-р байр,
Утас: 264216, Факс: 264460,
E-mail: info@csc.gov.mn

2021.01.20 № 01/201
танай _____-ны № _____-т

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ДАРГА
Ж.ГАНБААТАР ТАНАА

Ж. Ганбаатар
Мэргэшил! Мэргэшил!
Эрх

Мэргэшүүлэх багц сургалтын талаар

Улс орон даяар өндөржүүлсэн бэлэн байдал зарласан, цаг агаарын хүндрэл бэрхшээлтэй нөхцөлд бүх шатны төрийн байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулахад анхаарал хандуулан ажиллаж байна.

Төрийн албаны тусгай шалгалтыг зохион байгуулахад мэргэшүүлэх багц болон богино, дунд хугацааны сургалтыг хэрхэн тооцох тухай асуудлыг Төрийн албаны зөвлөлийн 2021 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 02 дугаар хуралдаанаар хэлэлцсэн болно.

Тусгай шалгалт зохион байгуулахдаа дараах чиглэлийг баримтлан ажиллах. Үүнд:

1. Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн үйлчлэх хугацааг сунгасантай холбоотойгоор өөрөөс нь үл хамаарах шалтгаанаар мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгсөөгүй бол, тухайн ангиллын мэргэшүүлэх багц сургалтад бүртгэгдсэн тухай Удирдлагын академийн лавлагааг үндэслэж төрийн албаны тусгай шалгалтын бүртгэлд хамруулах,

2. “Төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалд тавигдах тусгай шаардлагыг батлах тухай” Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 02 дугаар тогтоолын 06 дугаар хавсралтаар баталсан “Төрийн захиргааны гүйцэтгэх албан тушаалын дэс түшмэл, түүнтэй адилтгах гүйцэтгэх албан тушаалд тавигдах тусгай шаардлага”-ын “Туршлага” хэсэгт өөрчлөлт орсон тул албан тушаалын тодорхойлолтын “Мэргэшил” хэсэгт заасан “Төрийн албанд мэргэшүүлэх зохих багц сургалтад хамрагдаж төгссөн байх”, “Төрийн албанд мэргэшүүлэх богино болон дунд хугацааны сургалтад хамрагдаж төгссөн байх” гэснийг шаардахгүйгээр төрийн албаны тусгай шалгалтын бүртгэлд хамруулах,

3. Нэр дэвшиж томилогдсоны дараа нөхөж сургалтад хамруулах арга хэмжээ авахыг томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан мөрдөх.

ДАРГА



Б.БААТАРЗОРИГ

21000709